

## “ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь:</i>	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр/
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Түмэн шувуут” ХК, 000188646, MSE:TUM, 70005225
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын хөрөнгийн бирж
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	“Онч аудит” ХХК 2013-02-06
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	200,000,000
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Д.Наранцэцэг Хянасан: Гүйцэтгэх захирал Ж.Болд
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт <u>Тайланг хавсаргав</u>
	Орлогын тайлан <u>Тайланг хавсаргав</u>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан <u>Тайланг хавсаргав</u>
	Мөнгөн гүйлгээний тайлан <u>Тайланг хавсаргав</u>
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Жилийн эцсийн аудитын дүгнэлтийг хавсаргав.
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/

	Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын тодорхойлох захидлыг хавсаргана.																											
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																											
2.1.	<b>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</b>	<table border="1"> <tr> <td colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</td> </tr> <tr> <td colspan="2"><b>Ашигт ажиллагаа</b></td> </tr> <tr> <td colspan="2"> </td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA)</td> <td>17%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)</td> <td>25%</td> </tr> <tr> <td colspan="2"><b>Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</b></td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>30%</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td>40%</td> </tr> <tr> <td colspan="2"><b>Хөрөнгөнд эзлэх хувь</b></td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө</td> <td>68%</td> </tr> <tr> <td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td>32%</td> </tr> <tr> <td colspan="2"><b>Хөрвөх чадварын харьцаа</b></td> </tr> <tr> <td>Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө</td> <td></td> </tr> </table>	Санхүүгийн үзүүлэлтүүд		<b>Ашигт ажиллагаа</b>				Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	17%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	25%	<b>Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</b>		Нийт активын өөрчлөлт	30%	Зээлийн багцын өөрчлөлт	40%	<b>Хөрөнгөнд эзлэх хувь</b>		Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө	68%	Өр төлбөр/Нийт хөрөнгө	32%	<b>Хөрвөх чадварын харьцаа</b>		Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө	
Санхүүгийн үзүүлэлтүүд																												
<b>Ашигт ажиллагаа</b>																												
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	17%																											
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	25%																											
<b>Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</b>																												
Нийт активын өөрчлөлт	30%																											
Зээлийн багцын өөрчлөлт	40%																											
<b>Хөрөнгөнд эзлэх хувь</b>																												
Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө	68%																											
Өр төлбөр/Нийт хөрөнгө	32%																											
<b>Хөрвөх чадварын харьцаа</b>																												
Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө																												
2.2.	<b>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</b>																											
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	ОХУ-аас худалдан авдаг тэжээлийн түүхий эдийн үнийн өсөлт, тэжээл тасалдах хүндрэлээс урьдчилан сэргийлэх үүднээс БНХАУ-аас зарим түүхий эдийг худалдан авч байна.																										
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.																										
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<b>Тайлант хугацаанд:</b> “Түмэн шувуут-2” төслийн 6,7,8-р өндөглөгчийн байрнууд, өндөгний агуулах, агуулахын тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны тахианы аж ахуй эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Голомт банкнаас 8.5 тэрбум төгрөгийн зээл авсан. Зээлийн барьцаанд “Түмэн шувуут” ХК-ийн 6 үл хөдлөх хөрөнгө, 4 газар, 20 сая ширхэг хувьцаа, бараа материал болон ирээдүйд бий болох хөрөнгө /ТУЗ-																										

ийн 2023 оны 05 сарын 17-ны өдрийн хурлаар шийдвэрлэв./

- Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн бүтээн байгуулалтын ажил хийх зорилгоор



Хас банкнаас таван зуун сая төгрөгийн зээл авав. Зээлийн барьцаанд “Түмэн шувуут” ХК-ийн 6 үл хөдлөх хөрөнгө, 2 газар /ТУЗ-ийн 2023 оны 05 сарын 17-ны өдрийн хурлаар шийдвэрлэв./

- Тэжээлийн түүхий эд худалдан авах зорилгоор ХХААХҮЯ-наас олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Хаан банкнаас 1 тэрбум төгрөгийн зээл авсан. Зээлийн барьцаанд “Түмэн шувуут” ХК-ийн 4 үл хөдлөх хөрөнгө, 1 газар /ТУЗ-ийн 2023 оны 05 сарын 17-ны өдрийн хурлаар шийдвэрлэв./



*2023 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаарх зээлийн мэдээллийг хавсаргав.*

3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>
	<p>Байхгүй</p>
4.	<p><b>Цалин урамшууллын мэдээлэл</b></p>
	<p>2023 онд 2023 оны онд ТУЗ-ийн Хараат болон хараат бус гишүүдэд 28,4 сая төгрөг, Гүйцэтгэх удирдлагад 63 сая төгрөгийн цалин олгосон байна.</p>
5.	<p><b>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</b></p>
	<div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;">   </div> <div style="width: 50%;"> <ul style="list-style-type: none"> <li>• ТУЗ нь 2023 онд нийт 5 удаа хуралдаж, үүнээс цахимаар 2 удаа, Биечлэн оролцсон 2 удаа, эчнээ хэлбэрээр 1 удаа хуралдаж, нийт 26 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 18 шийдвэр гаргаж ажиллалаа. Мөн Нэр дэвшүүлэх хороо 1 удаа, Цалин урамшууллын хороо 2 удаа, Аудитын хороо 3 удаа, Ёс зүйн хороо 1 удаа тус тус хуралдаж холбогдох үүргийнхээ хувьд дүгнэлт гаргаж ажилласан байна.</li> <li>• ТУЗ нь компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс Ногдол ашгийн бодлого болон Мэдээллийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлахаас гадна Цалин, урамшууллын бодлого, Залгамж халааны бодлого, Эрсдэлийн удирдлагын заавар, Компанийн оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлогуудыг шинээр баталлаа. Мөн комплайнсын ажилтан томилж, комплайнсын хяналтын зааврыг батлан мөрдөн ажиллаж байна.</li> </ul> <p>Компанийн засаглалын кодексийн өөрийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг, Хүний нөөцийн менежер Б.Нямбаяр нар гаргаж, хянан баталгаажилтийн дүнгээр нийт 66 оноо буюу 91,6%-ийн үнэлгээ авсан. КЗК-ийн хүрээнд тайлант жилд нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлуудыг 2024 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан хийж гүйцэтгэх болно.</p> </div> </div>
6.	<p><b>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</b></p>
	<p>Байхгүй</p>
7.	<p><b>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</b></p>
	<p>Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2024 оны 04-р сарын 09-ны өдрийн байдлаар <b>15,409</b> үүнээс 5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигч 4 хүн буюу Л.Эрхэмбаяр 60,000,000 ширхэг хувьцаа-30%, Б.Тунгалаг 60,033,855 ширхэг хувьцаа ба 30,02%, Ж.Болд 20,000,000 ширхэг хувьцаа ба 10%, Э.Баяржаргал-20,000,000 ширхэг хувьцаа ба 10% тус тус эзэмшиж байна.</p>

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

2023 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй

9. Ногдол ашгийн мэдээлэл

2023 оны цэвэр ашгийн 30%-ийг Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилах шийдвэрийг 2024 оны 02-р сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас нэгж хувьцаанд 17,1 төгрөг тараах шийдвэр гаргаж, тус оны 09-р сарын 01-ны өдрийн дотор “ҮЦТХТ” ХХКомпаниар дамжуулан тараахаар болсон. Мөн Голомт капитал ҮЦКомпани “Голомт кастодиан”-нд бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг тус байгууллагын дансанд шилжүүлэх болно.

10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

### ХУВЬЦААТАЙ АЖИЛТАН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:



"ТҮМЭН ШУВУУТ" ТҮМНИЙ КОМПАНИ [www.tumenishuvuut.com](http://www.tumenishuvuut.com)  
[www.facebook.com/tumenishuvuut](https://www.facebook.com/tumenishuvuut)

“Түмэн шувуут” ХК-ийн нийт ажилчдын 50 гаруй хувь нь өөрийн компанийн хувьцааг эзэмшдэг бөгөөд компани ажилчидаа хувьцаажуулах хөтөлбөрийг тасралтгүй 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Энэ нь тухайн ажилтны сар бүрийн цалин дээр хувьцаа худалдан авах тодорхой хэмжээний мөнгийг байгууллагаас олгодог урамшуулалт хөтөлбөр юм. 2023 онд нийт **32,317,175** төгрөгийн хувьцааг ажилтнуудад авч өглөө. Мөн компанийнхаа хувьцаа эзэмшигч болохоор хүсэлтээ өгсөн 35 ажилтанд данс нээж хувьцаатай ажилтан хөтөлбөрт хамрууллаа.

### ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД: СУРГАЛТ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛУУД







**Ганзориг бизнес сургууль- Энергийн менежмент- 50 ажилтан 4 цагийн сургалт**  
**Манлайллын менежмент-30 ажилтан 2 цагийн сургалт**  
**Харилцагчийн үйлчилгээ- 20 ажилтан-2 цагийн сургалт**  
**Өндөр бүтээмжтэй борлуулагчийн ур чадвар-15 ажилтан 2 цагийн**

сургалт

**-Алтан чадамж сургалтын төв - Сэрээт ачигчийн оператор - 4 ажилтан 4 цагийн сургалт**

**- Монгол японы хөгжлийн төв - 5S хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нь- 150 ажилтан-16 цагийн сургалт**

**- МҮХАҮТ-ын дэргэдэх БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ТӨВ - Комплайнс, эрсдэлийн**



**удирдлага” сургалт 2 хүн-3 цагийн сургалт**

**- Хүний нөөцийн нэгж- PAINT TIME- уран зургийн сургалт-25 хүн 3 цагийн сургалт**

**Стандарт хэмжилзүйн газар- Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалт-1 хүн-8 цагийн сургалт**

**-Байгаль орчны менежментийн тогтолцооны сургалт -3 хүн- 8 цагийн сургалт**



- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг- Татварын мэргэшүүлэх сургалт-3 хүн 10 кредит цаг буюу 300 цагийн сургалт
- UPDATE нягтлан, няравын сургалтын төв- Няравын мэргэшүүлэх сургалт-2 хүн 48 цагийн сургалт
- Улаан загалмайн нийгэмлэг- Анхан шатны тусламжийн сургалт- 120 хүн- 3 цагийн сургалт
- EХА academy – Гэрэл зургийн сургалт -1 хүн 12 цагийн сургалт
  - Бүтээгдэхүүний зураг авалт- 1 хүн 8 цагийн сургалт



- БНХАУ-ын мэргэжилтэн -Шувууны аж ахуйн технологийн сургалт-25 хүн 16 цагийн сургалт
- БНХАУ-ын мэргэжилтэн -Инженер техникийн ажилтнуудын сургалт- 10 хүн – 4 цагийн сургалт
- Жайка ОУ-ын байгууллага, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, DPUB төвөөс зохион байгуулсан ААНБ-уудад зориулсан 8 дахь удаагийн нөлөөллийн сургалт- 2 хүн 8 цаг

**НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД: ОРГАНИК ХӨГЖИЛ ХАМТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН “ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**





“Түмэн шувуут” ХК нь органик бордооны үйлдвэрлэлийнхээ хүрээнд Органик хөгжил Хамтын Баталгаажуулалтын Байгууллагын гишүүн байгууллага байх эрхээ 2021 онд авсан бөгөөд түүнээс хойш тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож органик тариалалт, компостон бордоо үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, практик туршлага хослуулан хэрэгжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн ажил үйлчилгээг дэмжихэд өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Тус хамтын баталгаажуулалтын байгууллага нь гишүүн үйлдвэрлэгчийнхээ органик бүтээгдэхүүнийг жил бүр очиж магадлан баталгаажуулж, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аудит хийж ажилладаг.

Гишүүн байгууллагууд органик баталгаажуулалт хийлгэснээсээ хойш жил бүр магадлан баталгаажуулалт хийгэдэг бөгөөд өнгөрсөн хугацаанд Гэр гарден-Органик ХХК-ийн Саладны навч, Улаан лооль, Брокли, Хүрэн манжин, Чинцай, Өргөст хэмх зэрэг хүнсний ногоог магадлан баталгаажууллаа.

Баталгаажуулалтын ажилд ХББ-ын гишүүд: Л. Энхтуяа- [Урбан фермер Urban farmer](#), Б.Мөнгөнтуяа- Түмэн шувуут ХК-ийн [100% Компост Бордоо](#), Б.Нарангарав-Амгаланзаяа ЭҮ- [100% монгол орны ургамал](#), Ш.Будсүрэн-[FARM Market – нарны хороолол](#), ХААИС доктор Ж. Оюунгэрэл, ХААИС-ын докторант Ц.Болорхундага, УХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан А.Уранчимэг, Л.Баянзул нар оролцов.

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ ХУЧИН ЗҮЙЛИЙГ БАГАСГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД: ХАЯГДАЛ ЦААС ДАХИН БОЛОВСРУУЛАХ

  
ХАЯГДАЛ БОР ЦААС ИХ ХЭМЖЭЭГЭЭР  
БАЙНГА ХУДАЛДАЖ АВНА

1кг 70₮



ХАВТАСГУЙ, ҮДЭЭСГҮЙ, СКОЧГУЙ, ШОХОЙГУЙ,  
НААЛТГУЙ БАЙХ ШААРДЛАГАТАЙ

Утас: 8940-0930, 8889-1182



Иргэд, харилцагчдаас хаягдал цаасыг үнэлэн худалдан авч өндөгний цаасан үүр үйлдвэрлэж байна. Уг ажлын хүрээнд нийт **256 тн** хаягдал цаасыг ашиглаж цаасан үүр үйлдвэрлэжээ.

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ ХУЧИН ЗҮЙЛИЙГ БАГАСГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД: ХАЯГДАЛ САНГАСЫГ БОРДОО БОЛГОХ



Үйлдвэрээс гарах хаягдал буюу шувууны сангас жилд 2500 орчим тн хаягдаж, байгальд орчин, хөрс шороонд нөлөөлж байдаг. Үйлдвэрээс гарсан хаягдал сангасыг боловсруулан 2023 оны эхний хагаст нийт 116 тн 100% компост бордоо үйлдвэрлэв. Мөн бордоог хэрэглэх арга технологийг сайжруулан шингэн бордоо болгон боловсруулж худалдаанд гаргаад байна.



## ХЭРЭГЛЭГЧ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: “НАДАД АСУУЛТ БАЙНА, АХ, ЭГЧ НАРАА” ЗОРИЛТОТ КОНТЕНТ

Хэрэглэгчид болон харилцагч, хувьцаа эзэмшигч нарт зориулан өндөгний тухай мэдлэг олгох видео контент бэлтгэн өөрийн алабн ёсны Facebook page хуудсаар дамжуулан хүргэж байна. Хүүхдүүд өөрсдийн сонирхсон асуултаа дүрс бичлэгээр илгээж, түүнд нь компанийн мэргэжилтнүүд хариулт өгөх бөгөөд нийт 6 бяцхан хүүхдүүдийн асуултанд хариулт өгч ажиллалаа. хариулт өгөх бөгөөд нийт 6 бяцхан хүүхдүүдийн асуултанд хариулт өгч ажиллалаа.



## ХЭРЭГЛЭГЧ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: “УХААЛАГ, ХЭМНЭЛТТЭЙ СОНГОЛТ” УРИАЛГАД НЭГДЭЦГЭЭ



Байгаль орчноо хайрлахад бидний ухаалаг сонголт хамгийн чухал. Шошгоны зардлыг бууруулж, хэмнэлтийг хэрэглэгч ТАНД уриатайгаар ШОШГОГҮЙ савлагаатай ӨНДӨГ худалдаанд гаргав.

Судалгаагаар хэрэглэгчид бүтээгдэхүүн дээрх шошгоны мэдээллийг гол төлөв гар утаснаасаа авчихдаг гэсэн дүн байдаг тул өөрийн вэб сайтад шошгоны мэдээллийг байршуулж, QR код уншуулах зориулалттайгаар уг бүтээгдэхүүнийг худалдаанд гаргав.

## ХЭРЭГЛЭГЧ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: “ӨДӨР БҮР ӨНДӨГТЭЙ, ӨДӨР БҮР НОМТОЙ”



Хүүхдийг номонд дурлуулахын тулд эцэг эхийн оролцоо, хичээл зүтгэл хамгийн чухал. Эцэг эхийн хичээл зүтгэлд туслах 'Let's read' ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ цахим номын сангаас Монгол, Англи хэл дээр хүссэн үлгэрээ сонгож бяцхан хүүхдэдээ уншиж өгөх боломжтой сувиллын 10 болон бусад 30-тай савлагаатай өндөгний шошгийг QR кодтой болгон худалдаанд гаргасан.

## ХЭРЭГЛЭГЧ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: "ТҮМЭН ШУВУУТ" ХК-ТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Хэрэглэгчдийг өндөгний талаар бодит мэдээллээр хангах, өндөг нь хэрэглэгчийн гар дээр хүрэх хүртлээ хэчнээн дамжлага дамждагийг танилцуулах, хүүхдүүдэд танин мэдэхүй, хөдөлмөрийг хүндлэх боловсрол олгох зорилгоор танилцах аялалыг зохион байгуулав.

"Хөтөлбөрт 13-аас дээш насны, 20-45 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олныг долоо хоног бүрийн Бямба гарагийн 10:00 цагт хуваарийн дагуу үйлдвэртэй танилцууллаа. Нийт 250 орчим иргэд, хүүхдүүд хамрагдлаа.

**ТҮМЭН ШУВУУТ**  
ХААН-УУЛ ДУУРАГ  
ТЭГЭРХИЙН ХУМООР

**Танилцах аялал**


**ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**  
Хэрэглэгчдийг өндөгний талаар бодит мэдээллээр хангах, өндөг нь хэрэглэгчийн гар дээр хүрэх хүртлээ хэчнээн дамжлага дамждагийг танилцуулах, хүүхдүүдэд танин мэдэхүй, хөдөлмөрийг хүндлэх боловсрол олгох.

**ШУВУУНЫ АЖ АХУЙ-1**  
"Хөтөлбөрт хамрагдах хүүхдэд 13-аас дээш насны, 20-45 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олныг долоо хоног бүрийн Бямба гарагийн 11:00 цагт хуваарийн дагуу үйлдвэртэй танилцах аялалд урьж байна.

**АЯЛАГЧИД АНХААРАХ ЗҮЙЛС:**  
- Аялагчид 7000-8225 (1) дугаарт урьчилж бүртгүүлсэн байна.  
- Унааг аялагч өөрөө харуулна.  
- Аялагчид 15:30 минутад Түмэн Шувуут-1 дээр ирснэ байх, (хөдөрч болохгүй!)  
- Аялал 11:00 цагт эхэлнэ.  
- Аялагчид яуус, кофе, цай, агаан хөк, өндгөөр дайсна.  
- Насны хязгаар 13-с дээш.

**ХАЯГ**  
Хан-Уул дүүрэг 13-р хороо, Шувуун Фабрик, туул тогтоон Түмэн-Шувуут-1 шувууны аж ахуй.

## НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ.



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлд эрчимжсэн аж ахуйг кластер байдлаар төрөлжүүлэн хөгжүүлнэ гэж заасан ажлын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар "Түмэн шувуут" ХК-тай хамтран ажиллах Санамж бичиг байгуулав.

Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримталж буй бодлогын хүрээнд хот

орчмын мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд өндөр ашиг шимтэй, түргэн өсөлттэй эрчимжсэн мал аж ахуйн төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах юм.

Санамж бичигт "Түмэн шувуут" ХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд эрүүл хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ач тусыг сурталчлан таниулах зорилгоор жилд 9000 сурагчийг хүлээн авч, танилцах аялал зохион байгуулах хүчин чадал бүхий Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төв байгуулна гэж тусгасан. Ингэснээр ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутан залууст экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх боломж бүрдэх юм.

Санамж бичгийн хүрээнд хот орчмын доройтсон бэлчээрийг нөхөн сэргээж, харшилд гол нөлөө үзүүлж буй лууль, шарилжийн бэлчээрт эзлэх хувь хэмжээг бууруулах технологийг боловсруулан, хэрэгжүүлэхээр болсон.



**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ХҮРЭЭНД: НОГООН  
БАЙГУУЛАМЖ, ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ, МОД ТАРИХ, НОГООН ЗУРВАС  
БАЙГУУЛАХ**

**Түмэн шувуут-1 аж ахуй /ХУД-ийн 13-р хороо, Туул тосгон/**



Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны нийтийн эзэмшлийн зам талбайд буюу “Түмэн шувуут-1” аж ахуйн эргэн тойронд 3600 м/2 талбайд ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна.



**Түмэн шувуут-2 аж ахуй /СХД-ийн 21-р хороо, Их булаг/**



“Түмэн шувуут” ХК нь шинээр байгуулж байгаа “Түмэн шувуут-2” шувууны аж ахуйн бүтээн байгуулалтын ажлын нэг хэсэг болгож хамгаалалтын зурвас буюу үйлдвэрийн эзэмшлийн 20000 м/2 газрыг тойруулан нийтдээ 1600 ширхэг улиас модыг тарьж 98%-ийн ургалттай, 1000м/2 талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг хийгээд байна.



**Тэжээлийн үйлдвэр /СХД-ийн 21-р хороо, Рашаант өртөө/**



**Тэжээлийн үйлдвэрийн эзэмшлийн талбайд 400 м/2 газарт ногоон байгууламж,**



зүлэгжүүлэлт, хамгаалалтын зурвас бүхий 400 ширхэг улиас мод, 2600 м/2 газарт нөхөн сэргээлтийн зүлэгжүүлэлт, 20 га талбайд ногоон тэжээл тариалах ажлуудыг тус тус хийж гүйцэтгээд байна.



## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:



“ТҮМЭН ШУВУУТ-2” ФЕРМИЙГ ШИНЭЭР  
БАРЬЖ, БҮРЭН АШИГЛАЛТАНД  
ОРУУЛЛАА.

“Түмэн шувуут-2” төсөл бүрэн хэрэгжсэнээр нэмэлтээр 80 сая ширхэг өндөг үйлдвэрлэх ба 80 хүнийг ажлын байраар хангаж, 32 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэх боломжтой болсон.

Бидний хувьд 2022 онд 97.7 сая ширхэг өндөг зах зээлд нийлүүлсэн бол 2023 онд 117 сая ширхэг өндөг үйлдвэрлэж, хүчин чадлаа цаашид улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Одоогийн байдлаар "Түмэн шувуут" хувьцаат компани 100% дотоодын хөрөнгө оруулалттай, нийт 600 мянган өндөглөгч тахиатай, 200 мянган дэгдээхэйтэй, нэг ээлжиндээ 153 мянган ширхэг өндөг дарах хүчин чадал бүхий инкубаторын цехтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

## ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:



“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж "ТҮМЭН ШУВУУТ-3" шувууны аж ахуй байгуулах төслийг 2024 оноос эхлүүлэх шийдвэрийг гаргасан.

"Түмэн шувуут-3" төсөл нь 2024-2026 оны хугацаанд хэрэгжих бөгөөд төслийн үр дүнд шувууны тоо толгой 1,000,000-д хүрч, жилд нийтдээ 230,000,000 ширхэг өндөг үйлдвэрлэх бөгөөд, энэ нь дотоодын өндөгний хэрэглээг 100% хангах зорилгод өөрийн хувь нэмрээ

оруулан ажиллах боломж бүрдэх юм.

"ТҮМЭН ШУВУУТ-3" төсөл хэрэгжиж дууссанаар 100-120 хүний шинэ ажлын байр нэмэгдэнэ.

## БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД: САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛИМПИАДЫГ САНХҮҮЖҮҮЛЛЭЭ.



“Түмэн шувуут” ХК нь Монголын Санхүүгийн шинжээчдийн нийгэмлэгээс санаачлан жил бүр зохион байгуулдаг CFA Institute Research Challenge тэмцээнийг ивээн тэтгэж оролцлоо. Энэ удаагийн тэмцээнд ялсан баг Ази Номхон Далайн бүсийн тэмцээнд өрсөлдөх эрх

авсан бөгөөд уг тэмцээн нь Монгол улсад 2017 оноос хойш 7 дахь жилдээ зохион байгуулагдаж байна.

- МУИС-ын "SIRIUS" баг тэмцээнд ялалт байгуулж Нэгдүгээр байр,
- Хоёрдугаар байрыг Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн "Шар шувуунууд" баг
- Гуравдугаар байрыг МУИС-ийн "Meta Genius" баг тус тус хүртлээ. Оролцсон бүх багууд CFA Институтийн сүлжээгээр дамжуулан санхүүгийн шинжилгээ, мэргэжлийн ёс зүйн эрчимжүүлсэн сургалт, тэдний багш зөвлөх, салбарын ментороор дамжуулан сургалт авсан юм.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: ЖИГЖИД овогтой БОЛД

Овог, нэр: .....

Албан тушаал: "Түмэн шувуут" ХК-ийн гүйцэтгэх захирал

Албан тушаал: "Онч аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Наранцэцэг

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: *Д. Наранцэцэг* .....